

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
3. Менежментийн захидал	9
3.1 Цалин хөлсний талаар	9
3.2 Тайлагналын талаар.....	9
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
НББСШУ	Нийгмийн бодлого боловсрол соёл шинжлэх ухаан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Я.ТӨМӨРБААТАР ТАНАА

2020.03.13 № 06/855
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Монгол улсын их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол улсын их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол улсын их сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус хүрээлэнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



᠑᠑᠐᠖1᠐᠑
᠑᠐1᠑1203᠑᠖

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол улсын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн бараа материалын тайланг үнэн зөв гаргаж байх, үндсэн хөрөнгө, шатахууны зардал, цалин хөлсийг үнэн зөв тооцож байх, холбогдох хууль журам зааврыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол улсын их сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол улсын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 23-аас 2020 оны 03 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар Голден пэйж Аудит ХХК-ийн захирал С.Оюунгэрэл хянан удирдаж, аудитор Я.Оюун, Ц.Долгормаа, Б.Дашням, Б.Одгэрэл нар хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол улсын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 1/364 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол улсын их сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь: “Дэлхийн түвшний их сургууль” болоход оршино. Үүний дүнд 2024 онд чөлөөт мэдлэг буюу “либерал арт” уламжлалд суурилсан, бүс нутгийн хэмжээнд тэргүүлэх байр суурьтай судалгааны их сургууль болж, улмаар Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд багтаж орох зорилго, зорилтуудыг дэвшүүлэн зорилгоо хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол улсын их сургуулийн үйл ажиллагааны чиглэл:

- Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний дагуу 2019 онд 7 чиглэлийн 35 арга хэмжээний хүрээнд 114 үйл ажиллагаа, тусгай 7 арга хэмжээний хүрээнд 10 үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллаж байна.
- Удирдлагын менежмент, зохион байгуулалтын чанарыг сайжруулах чиглэлээр удирдах ажилтнуудтай үр дүнгийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр үнэлж дүгнэдэг, үр дүнд суурилсан удирдлагын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.
- МУИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөр, 2019-2024 дунд хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулан баталлаа.
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд багш бүр судалгааны, сургалтын, хувь хүний гэсэн үндсэн 3 цогц чадамжийн хүрээнд өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх талаарх бодлого, төлөвлөлт, сургалт, үйлчилгээ явуулах зэрэг ажлыг 2019-2020 оны хичээлийн жилээс үе шаттай хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Сургуулийн удирдлага дараах хууль болон хөтөлбөрүүдийг мөрдөн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Дээд боловсролын тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хууль
- Нийгмийн даатгалын багц хууль
- Засгийн газрын “Боловсрол” үндэсний хөтөлбөр
- Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
- Монгол улсын их сургуулийн стратегийн төлөвлөгөө

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд “нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ”
- Хөдөлмөрийн тухай хуулийн 76 дугаар зүйлд “нийтээр амрах баярын өдөр”
- ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлд “албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх” гэсэн заалтуудад тус тус өөрчлөлт орсон байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол улсын их сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Powersoft” программ хангамж ашиглаж байна.

Монгол улсын их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Монгол улсын их сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 чиглэлийн 14 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 49,563.1 сая төгрөгөөс тооцон 495.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 896.4 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Монгол улсын их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,809.8 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	31,567.2	39,843.4	8,276.2
Авлага	2,439.6	812.6	(1,627.0)
Урьдчилгаа тооцоо	294.1	456.5	162.5
Бараа материал	2,467.4	2,757.6	290.1
Үндсэн хөрөнгө	84,090.7	87,727.7	3,637.0
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(14,344.3)	(18,272.6)	(3,928.2)
Биет бус хөрөнгө	328.6	365.3	36.7
Биет бус хөрөнгийн элэгдэл	(154.0)	(191.4)	(37.4)
Нийт хөрөнгө	106,689.3	113,499.1	6,809.8
Богино хугацаат өр төлбөр	5,587.4	3,703.5	(1,883.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	20,201.5	20,201.5	
Хуримтлагдсан үр дүн	69,024.3	77,718.1	8,693.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,875.9	11,875.9	
Цэвэр хөрөнгө, өмчийн дүн	101,101.9	109,795.6	8,693.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	106,689.3	113,499.1	6,809.8

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 8,276.2 сая төгрөгөөр өссөн нь төсөл хөтөлбөрийн тоо, орлого нэмэгдсэн, хүүгийн орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 1,627.0 сая төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага буюу тогтмол зардал болох ашиглалтын зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй шийдвэр гарсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,637.0 сая төгрөгөөр өссөн нь сургалтын тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, ном худалдаж авсантай холбоотой.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол улсын их сургуулийн Удирдах зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 5 дугаар тогтоолоор зорилтот түвшний орлого 85,147.6 сая төгрөг, зарлага 71,252.6 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант хугацаанд нийт 97,823.4 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс үндсэн үйл ажиллагааны орлого 59,192.9 сая төгрөг, бусад орлого 37,458.3 сая төгрөг хандив, тусламжийн орлого 1,061.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 110.5 сая төгрөг, төсвийн захирагчдаас 161.7 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас санхүүжих 0.4 сая төгрөг тус тус олжээ.

Нийт зардлын 3,085.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 43,602.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан зорилтот түвшний гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлд 51,392.5 сая төгрөг зарцуулах төсөв батлагдсанаас 46,407.3 сая төгрөгийг зарцуулжээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 14 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн нийт 2.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 акт тогтоосон.

1. Мөнгөн хөрөнгөнөөс 2.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2 заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитаар нийт 78.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2.1 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 76.5 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цаашид анхаарах шаардлагатай газрын маргаантай дараах асуудлууд байна.

Үүнд:

- ✓ Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2010 оны 11 сарын 30-ны өдрийн 781 тоот шийдвэрээр 391 метр квадрат газрыг оюутны байр, конторын зориулалтаар эзэмшүүлсэн. Газрын төлбөрийг жил бүр төлдөг. Уг газрыг Засгийн газрын 2016 оны 193-р тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалыг үндэслэн 2018 онд эзэмших эрхийн үнэлгээг 12.7 сая төгрөгөөр үнэлэн санхүүгийн тайланд Дуусаагүй барилга нэрээр бүртгэж тайлагнасан. Уг газрын суурийг тус сургууль хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд өөр эзэмшигч нэр дээрээ шилжүүлэн авч 4 давхар барилгын карказд хөрөнгө оруулсан байна.
- ✓ Нийслэлийн засаг даргын 2007 оны 04-р сарын 02-ны өдрийн 129 тоот шийдвэрээр 12,806.0 м.кв газрыг Боловсролын байгууллагын зориулалтаар эзэмших зориулалттайгаар 000001832 тоот гэрчилгээг 2019 оны 01-р сарын 22-ны өдөр баталгаажуулсан. Тус эзэмшил газарт өөр байгууллагын санхүүжүүлэлтээр Спорт цогцолборын барилгын 3 давхар карказ баригдсан байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монгол улсын их сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 18 нэгж бүрэлдэхүүн сургуулийн хүрээнд 2296 мэдээллийг хугацаанд нь, 101 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6 зөвлөмж, 2 албан шаардлага өгснөөс 6 зөвлөмж 2 албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллажээ.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол улсын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол улсын их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Цалин хөлсний талаар

3.1.1. Илрүүлэлт:

Цалин хөлсний нэмэгдлийн дүнгийн ангиллыг буруу бүртгэж тайлагнасан илүү цагийн хөлсийг шөнийн цагийн нэмэгдэл нэрээр бүртгэсэн байна.

Энэ нь стандартын дагуу санхүүгийн тайлангийн үнэн зөв ангилж, тодруулж тайлагнасан байх; зөв хуваарилсан байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй, холбогдох хууль тогтоомж хэрэгжихгүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Цалингийн зардлын ангиллыг үнэн зөв бүртгэх санхүүгийн программдаа өөрчлөлт хийлгүүлэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Санхүүгийн "Поверсофт" программ хангамжид цалин хөлсний бүртгэлд холбогдох засварыг хийлгэсэн

3.2 Тайлагналын талаар

3.2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нь улсын бүртгэлийн гэрчилгээний дүнгээс зөрүүтэй байна.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14-д "Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл" өөрчлөгдсөн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллагад өөрчлөлтийг бүртгэнэ гэсэн заалтыг хангахгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй, холбогдох хууль тогтоомж хэрэгжихгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Улсын бүртгэлд зохих нэмэлт өөрчлөлтийг хийлгүүлж, дүрмийн сангаа нэмэгдүүлэн албажуулан бүртгүүлэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

МУ-ын ЗГ-ын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалыг хэрэгжүүлж, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийснээр дүрмийн сан өссөн. Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлтийг оруулж ажиллана.

3.3 Цахим баримтын талаар

3.3.1 Илрүүлэлт:

Цахим баримтанд 8.0 сая төгрөгийг Монгол улсын их сургуулийн регистрийн дугаараар илүү шивэлт хийдэг, гүйлгээний утгыг хянадаггүй байдал ажиглагдлаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.3.2 Эрсдэл

Санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.3.3 Зөвлөмж

Цахим баримтад тавих хяналтыг сайжруулж, Нягтлан бодох бүртгэлийн хууль, төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид цахим баримтын хяналтыг сайжруулан ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,768,314,797.14	43,870,084,169.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	31,567,199,882.93	39,843,367,635.76
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	12,516,869.12	-
31110	Төгрөг	12,516,869.12	
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	31,554,683,013.81	39,843,367,635.76
3121	Төгрөг	29,491,918,873.67	27,186,881,251.37
31213	Арилжааны банк дахь харилцах	29,491,918,873.67	27,186,881,251.37
3122	Гадаад валют	2,062,764,140.14	12,656,486,384.39
31223	Арилжааны банк дахь харилцах	2,062,764,140.14	12,656,486,384.39
33	АВЛАГА	2,439,613,516.75	812,599,716.37
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	285,725,804.38	620,467,670.73
335	Бусад авлага	2,153,887,712.37	192,132,045.64
3351	Байгууллагаас авах авлага	2,153,887,712.37	192,132,045.64
34	УРЬДЧИЛГАА	294,077,135.50	456,554,993.47
3471	Урьдчилгаа тооцоо	294,077,135.50	456,554,993.47
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	97,837,135.50	195,886,993.47
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	196,240,000.00	260,668,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,467,424,261.96	2,757,561,824.23
351	Түүхий эд материал	7,139,958.57	6,385,941.63
35110	Тусгай зориулалттай материал	6,303,300.62	4,801,153.11
35130	Эм боох материал	836,657.95	1,584,788.52
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	69,910,777.00	69,910,777.00
354	Хангамжийн материал	2,390,373,526.39	2,681,265,105.60
35410	Бичиг хэргийн материал	6,120,630.04	9,046,766.97
35420	Аж ахуйн материал	520,919,977.79	713,214,580.25
35430	Сэлбэг хэрэгсэл	116,906,951.04	118,272,076.61
35440	Түлш, шатах тослох материал	893,298.70	2,983,299.20
35450	Барилгын засварын материал	26,480,289.28	25,890,067.52
35460	Хүнсний материал	4,214,908.53	1,159,405.63
35470	Бусад хангамжийн материал	1,714,837,471.01	1,810,698,909.42
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	69,920,958,911.74	69,628,986,199.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	69,920,958,911.74	69,628,986,199.28
392	Биет хөрөнгө	65,836,689,141.66	65,256,288,836.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	51,769,824,740.16	51,770,366,516.67
39202	Хуримтлагдсан элэгдэл	415,337,658.32	2,042,750,511.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	354,393,936.00	744,393,936.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	326,208,400.33	362,638,147.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,325,804,469.65	20,641,477,432.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	10,063,879,452.37	12,021,128,329.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,724,336,819.02	7,034,359,317.95
39208	Хуримтлагдсан элэгдэл	3,422,787,727.57	3,719,160,058.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	175,184,948.51	234,423,247.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	116,112,001.77	126,938,477.69
39216	Дуусаагүй барилга, байгууламж	160,000,000.00	160,000,000.00

39217	Ном	2,671,469,468.68	2,943,883,910.59
393	Биет бус хөрөнгө	4,084,269,770.08	4,372,697,362.70
39301	Програм хангамж	328,601,676.91	365,307,447.01
39302	Хуримтлагдсан элэгдэл	154,002,616.83	191,355,392.31
39303	Бусад биет бус хөрөнгө	3,909,670,710.00	4,198,745,308.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>106,689,273,708.88</u>	<u>113,499,070,369.11</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,587,390,563.43</u>	<u>3,703,465,318.59</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,587,390,563.43	3,703,465,318.59
413	Өглөг	465,144,147.51	756,911,218.73
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	74,901,857.67	64,147,972.17
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	183,973,377.42	98,657,353.31
4136	Бусад өглөг	206,268,912.42	594,105,893.25
41361	Байгууллагад төлөх өглөг	150,122,322.60	406,615,656.40
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	251,299.82	32,278,496.85
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	55,895,290.00	155,211,740.00
414	Урьдчилж орсон орлого	5,122,246,415.92	2,946,554,099.86
41440	Бусад урьдчилж орсон орлого	5,122,246,415.92	2,946,554,099.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>101,101,883,145.45</u>	<u>109,795,605,050.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	101,101,883,145.45	109,795,605,050.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,201,535,374.47	20,201,535,374.47
51101	Өмч: - төрийн	20,201,535,374.47	20,201,535,374.47
512	Хуримтлагдсан үр дүн	69,024,366,033.67	77,718,087,938.74
51210	Өмнөх үеийн үр дүн	62,055,467,664.13	69,024,366,033.67
51220	Тайлант үеийн үр дүн	6,968,898,369.54	8,693,721,905.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,875,981,737.31	11,875,981,737.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>106,689,273,708.88</u>	<u>113,499,070,369.11</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	77,312,687,368.86	97,985,561,325.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,955,006,524.27	97,823,410,183.96
120	Нийтлэг татварын бус орлого	72,791,955,024.27	96,651,061,150.96
120002	Хүүгийн орлого		3,013,753,035.05
120003	Торгуулийн орлого	323,714,336.73	268,253,822.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,947,746,202.12	55,910,752,578.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,341,068,009.44	46,518,019,953.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,841,668,850.48	8,733,689,095.32
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	333,255,769.90	659,043,529.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	431,753,572.30	
120009	Бусад орлого	23,520,494,485.42	37,458,301,714.73
122	Тусламжийн орлого	39,498,800.00	1,061,804,433.00
122001	Хандив тусламж /дотоод/	39,498,800.00	791,706,200.00
122002	Хандив тусламж / гадаад/		270,098,233.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	123,552,700.00	110,544,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	123,552,700.00	110,544,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,357,680,844.59	162,151,141.61
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,202,551,289.75	
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	3,202,551,289.75	
1330	Төсвийн захирагчдаас	1,146,014,019.14	161,762,440.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	45,645,000.00	102,271,040.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	1,066,669,019.14	
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	33,700,000.00	59,491,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9,115,535.70	388,701.61
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9,115,535.70	388,701.61
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	45,189,386,156.29	50,317,986,612.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,189,386,156.29	50,317,986,612.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	44,807,339,256.29	49,727,690,397.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,637,127,427.75	27,047,102,999.39
210101	Үндсэн цалин	25,637,127,427.75	27,047,102,999.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,086,428,670.69	3,447,778,883.41
210201	Тэтгэврийн даатгал	1,964,090,972.26	2,192,787,369.85
210202	Тэтгэмжийн даатгал	224,467,539.69	251,687,858.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	280,584,424.60	313,747,878.39
210204	Ажилгүйдлийн даатгал	56,116,884.93	62,060,019.90
210205	Эрүүл мэндийн даатгал	561,168,849.21	627,495,756.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,069,301,117.42	1,120,417,992.74

Монгол улсын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	532,428,825.04	575,254,213.57
210302	Түлш, халаалт	393,966,379.31	378,294,784.78
210303	Цэвэр, бохир ус	142,905,913.07	166,868,994.39
2104	Хангамж, бараа материалын зардал	1,011,098,933.01	1,096,513,135.44
210401	Бичиг хэрэг	152,162,970.60	110,939,046.20
210402	Тээвэр, шатахуун	31,993,032.68	34,297,049.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	241,658,470.81	252,840,237.81
210404	Ном, хэвлэл	101,132,312.41	79,759,023.28
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	484,152,146.51	618,677,778.85
2105	Нормативт зардал	5,232,979.65	1,871,439.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,866,160.46	1,871,439.43
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,366,819.19	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	788,421,249.75	725,508,147.67
210604	Урсгал засвар	788,421,249.75	725,508,147.67
2107	Томилолт, зочны зардал	532,090,529.61	712,497,703.99
210701	Гадаад албан томилолт	127,381,727.40	182,107,416.35
210702	Дотоод албан томилолт	28,139,570.00	27,874,817.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	376,569,232.21	502,515,470.64
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	640,270,814.75	638,650,902.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	630,637,379.50	638,650,902.62
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	9,633,435.25	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,037,367,533.66	14,934,349,192.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	208,726,639.67	696,052,785.85
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,840,391,484.83	9,429,223,002.58
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,988,249,409.16	4,809,073,404.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	382,046,900.00	593,296,214.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	382,046,900.00	593,296,214.93
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	382,046,900.00	593,296,214.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	32,123,301,212.57	45,864,230,880.08
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	194,765,212.12	348,947,871.49
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	194,765,212.12	348,947,871.49
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,349,168,055.15	39,322,800,679.42
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,802,840,857.17	13,356,048.61
225002	Найдваргүй авлагын алдагдал		1,803,343,832.92
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	25,832,712.56	47,799,083.16
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	23,520,494,485.42	37,458,301,714.73
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(25,154,402,843.03)	(38,973,852,807.93)
5	НИЙТ ҮР ДҮН	6,968,898,369.54	8,693,721,905.07

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12 сарын 31	2019 оны 12 сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>53,296,176,183.19</u>	<u>58,132,524,685.61</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,270,443,871.19	49,906,428,280.41
120	Нийтлэг татварын бус орлого	48,146,891,171.19	49,906,428,280.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,146,891,171.19	49,906,428,280.41
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	38,904,938,985.12	38,255,816,528.91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,911,180,116.17	11,650,611,751.50
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	330,772,069.90	
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	123,552,700.00	
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	123,552,700.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,025,732,312.00	8,226,096,405.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,596,387,312.00	8,226,096,405.20
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	4,596,387,312.00	7,139,433,476.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		976,118,329.20
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		110,544,600.00
1330	Төсвийн захирагчдаас	429,345,000.00	
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	45,645,000.00	
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	350,000,000.00	
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	33,700,000.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>41,766,483,001.91</u>	<u>46,214,009,350.19</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,766,483,001.91	46,214,009,350.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,432,005,811.91	45,669,137,078.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,433,893,996.36	27,051,579,143.98
210101	Үндсэн цалин	25,433,893,996.36	27,051,579,143.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,364,788,915.52	3,401,249,204.59
210201	Тэтгэврийн даатгал	1,962,793,534.05	2,163,194,494.12
210202	Тэтгэмжийн даатгал	280,399,076.29	248,291,191.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	504,718,337.33	309,513,677.62
210204	Ажилгүйдлийн даатгал	56,079,815.26	61,222,485.68
210205	Эрүүл мэндийн даатгал	560,798,152.59	619,027,355.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,066,669,019.14	1,129,841,717.03
210301	Гэрэл, цахилгаан	532,428,825.04	573,100,683.76
210302	Түлш, халаалт	391,334,281.03	384,844,068.88
210303	Цэвэр, бохир ус	142,905,913.07	171,896,964.39
2104	Хангамж, бараа материалын зардал	1,058,780,072.40	1,034,602,713.67
210401	Бичиг хэрэг	65,185,758.03	60,529,830.00
210402	Тээвэр, шатахуун	35,553,604.00	38,742,425.24
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	237,199,118.34	247,630,508.62
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	720,841,592.03	687,699,949.81
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	835,508,669.28	774,020,767.89
210604	Урсгал засвар	835,508,669.28	774,020,767.89
2107	Томилолт, зочны зардал	538,575,226.48	717,702,551.65
210702	Дотоод албан томилолт	60,693,650.00	35,681,048.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	477,881,576.48	682,021,503.65

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	382,133,789.82	413,339,502.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	299,520,000.00	343,160,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	82,613,789.82	70,179,502.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,751,656,122.91	11,146,801,477.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	528,014,413.33	572,041,101.19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,223,641,709.58	10,574,760,375.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	334,477,190.00	544,872,271.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	334,477,190.00	544,872,271.50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	221,163,140.00	447,178,653.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,314,050.00	97,693,618.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	11,529,693,181.28	11,918,515,335.42
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	3,726,391,044.38	3,642,347,582.59
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,726,391,044.38	3,642,347,582.59
2200	Дотоод эх үүсвэрээр	3,726,391,044.38	3,642,347,582.59
222001	Тоног төхөөрөмж	292,081,112.76	64,428,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,434,309,931.62	3,577,919,582.59
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(3,726,391,044.38)	(3,642,347,582.59)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,803,302,136.90	8,276,167,752.83
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,763,897,746.03	31,567,199,882.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,567,199,882.93	39,843,367,635.76

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,291,864,664.47	17,783,332,342.48	44,272,135,321.65	78,347,332,328.60
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,909,670,710.00		17,783,332,342.48	21,693,003,052.48
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,201,535,374.47	17,783,332,342.48	62,055,467,664.13	100,040,335,381.08
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		(5,907,350,605.17)		(5,907,350,605.17)
C07	Тайлант үеийн үр дүн			6,968,898,369.54	6,968,898,369.54
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,201,535,374.47	11,875,981,737.31	69,024,366,033.67	101,101,883,145.45
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,201,535,374.47	11,875,981,737.31	69,024,366,033.67	101,101,883,145.45
D08	Тайлант үеийн үр дүн			8,693,721,905.07	8,693,721,905.07
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,201,535,374.47	11,875,981,737.31	77,718,087,938.74	109,795,605,050.52

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,252,615,670.00	49,856,356,932.78	21,396,258,737.22	70.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,392,543,550.00	46,407,321,925.89	4,985,221,624.11	90.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,790,337,130.00	45,862,449,654.39	4,927,887,475.61	90.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,163,339,280.00	27,051,579,143.98	2,111,760,136.02	92.8
210101	Үндсэн цалин	29,163,339,280.00	27,051,579,143.98	2,111,760,136.02	92.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,645,126,810.00	3,401,249,204.59	243,877,605.41	93.3
210201	Тэтгэврийн даатгал	2,318,300,651.16	2,163,194,494.12	155,106,157.04	93.3
210202	Тэтгэмжийн даатгал	266,094,257.14	248,291,191.94	17,803,065.20	93.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	331,706,539.71	309,513,677.62	22,192,862.09	93.3
210204	Ажилгүйдлийн даатгал	65,612,282.58	61,222,485.68	4,389,796.90	93.3
210205	Эрүүл мэндийн даатгал	663,413,079.41	619,027,355.23	44,385,724.18	93.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,178,059,390.00	1,129,841,717.03	48,217,672.97	95.9
210301	Гэрэл, цахилгаан	553,550,440.00	573,100,683.76	(19,550,243.76)	103.53
210302	Түлш, халаалт	450,472,980.00	384,844,068.88	65,628,911.12	85.43
210303	Цэвэр, бохир ус	174,035,970.00	171,896,964.39	2,139,005.61	98.77
2104	Хангамж, бараа материалын зардал	1,244,522,180.00	1,059,652,968.67	184,869,211.33	85.15
210401	Бичиг хэрэг	120,176,200.00	60,529,830.00	59,646,370.00	50.4
210402	Тээвэр, шатахуун	55,653,500.00	38,742,425.24	16,911,074.76	69.62
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	315,486,460.00	247,630,508.62	67,855,951.38	78.49
210404	Ном, хэвлэл	34,163,650.00	31,799,005.00	2,364,645.00	93.08
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	719,042,370.00	680,951,199.81	38,091,170.19	94.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,419,063,830.00	774,020,767.89	645,043,062.11	54.55
210604	Урсгал засвар	1,419,063,830.00	774,020,767.89	645,043,062.11	54.55
2107	Томилолт, зочны зардал	1,055,111,750.00	717,702,551.65	337,409,198.35	68.02
210701	Гадаад албан томилолт	909,775,500.00	657,464,361.25	252,311,138.75	72.27
210702	Дотоод албан томилолт	69,866,420.00	35,681,048.00	34,185,372.00	51.07
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	75,469,830.00	24,557,142.40	50,912,687.60	32.54
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	460,112,110.00	413,339,502.75	46,772,607.25	89.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	354,860,010.00	343,160,000.00	11,700,010.00	96.71

Монгол улсын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	105,252,100.00	70,179,502.75	35,072,597.25	66.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,625,001,780.00	11,315,063,797.83	1,309,937,982.17	89.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,653,098,510.00	1,531,416,291.05	121,682,218.95	89.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,971,903,270.00	9,783,647,506.78	1,188,255,763.22	89.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	602,206,420.00	544,872,271.50	57,334,148.50	90.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	602,206,420.00	544,872,271.50	57,334,148.50	90.48
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	504,359,820.00	447,178,653.00	57,181,167.00	88.66
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	97,846,600.00	97,693,618.50	152,981.50	99.84
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,860,072,120.00	3,449,035,006.89	16,411,037,113.11	17.37
2200	Дотоод эх үүсвэрээр	19,860,072,120.00	3,449,035,006.89	16,411,037,113.11	17.37
220001	Барилга байгууламж	12,432,410,000.00	289,074,598.00	12,143,335,402.00	2.32
221001	Их засвар	109,413,670.00	84,271,541.00	25,142,129.00	77.02
222001	Тоног төхөөрөмж	5,065,169,550.00	2,105,408,734.45	2,959,760,815.55	41.57
223001	Бусад хөрөнгө	2,253,078,900.00	970,280,133.44	1,282,798,766.56	43.06
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	53,580,440,920.00	58,132,524,685.61	4,552,083,765.61	91.51
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,966,448,840.00	1,086,662,929.20	1,879,785,910.80	36.63
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,780,000,000.00		1,780,000,000.00	100.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	112,177,800.00	110,544,600.00	1,633,200.00	98.54
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,074,271,040.00	976,118,329.20	98,152,710.80	90.86
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨССАНХҮҮЖИХ	118,683,000.00	120,954,100.00	(2,271,100.00)	98.09
132001	Орон нутгийн төсвөөс	118,683,000.00	120,954,100.00	(2,271,100.00)	98.09
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	50,495,309,080.00	56,924,907,656.41	(6,429,598,576.41)	87.27
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,517,345,420.00	45,014,734,184.91	(4,497,388,764.91)	88.91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,977,963,660.00	11,910,173,471.50	(1,932,209,811.50)	80.64
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		31,567,199,882.93		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		39,843,367,635.76		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.12	Аудитын нэр: Монгол улсын их сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/111/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Монгол улсын их сургууль	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалин хөлсний талаар	68.5	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Я.Төмөрбаатар, Б.Энхцэцэг
2	Цахим баримтын талаар	8.0	Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Я.Төмөрбаатар, Б.Энхцэцэг
3	Зардлын талаар	2.1	Акт тогтоосон	Дарга, Ахлах нягтлан бодогч	Я.Төмөрбаатар, Б.Энхцэцэг
4	Тайлагналын талаар		Аудитын зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Я.Төмөрбаатар, Б.Энхцэцэг
	Дүн	78.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 23 № 02/71
СНТ-2020/111/СТА-ТӨЧГ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол улсын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Үүнд: Мөнгөн хөрөнгөнөөс 2,100,000 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.2-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.2-т "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Монгол Улсын Их сургуулийн 2,100,000 /Хоёр сая нэг зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 10090000601 дүгээр дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2020 оны 06-р сарын 30-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол улсын их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар, Санхүү, төлөвлөлтийн газрын дарга Б. Энхцэцэг нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН:
 САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
 ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 Ц.НАРАНЧИМЭГ
 АХЛАХ АУДИТОР
 Д.ЦЭРЭНДОРЖ
 ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК
 ЗАХИРАЛ
 С.ОЮУНГЭРЭЛ

ЗӨВШӨӨРСӨН:
 МОНГОЛ УЛСЫН ИХ
 СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
 ГҮЙЦЭТГЭГЧ
 Я.ТӨМӨРБААТАР
 САНХҮҮ ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
 ДАРГА
 Б.ЭНХЦЭЦЭГ
 УУД0072-9104399

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kherep\Akt\2020\0319SAG2.Docx

001090166



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 28

№ 02/71

САГ-2020/111/СТА-794Г

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол улсын их сургуулийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ.

Үүнд: Мөнгөн хөрөнгөнөөс 2,100,000 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1,6.4.2-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 6.4.2-т"төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т " Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Монгол Улсын Их сургуулийн 2,100,000 /Хоёр сая нэг зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 100900000601 дүгээр дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2020 оны 06-р сарын 30-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол улсын их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Төмөрбаатар, Санхүү, төлөвлөлтийн газрын дарга Б. Энхцэцэг нарт хариуцуулав.

АКТ

ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР
Д.ЦЭРЭНДОРЖ

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ
С.ОЮУНГЭРЭЛ

ЗӨВШӨӨРСӨН:
МОНГОЛ УЛСЫН ИХ
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ
Я.ТӨМӨРБААТАР
САНХҮҮ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА
Б.ЭНХЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тасвсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10\Richie_Kheree\Akt\2020\0319SAG2.Docx

001090167

